

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019-02-20

Тендер шалгаруулалтын нэр: Цагдаагийн газрын барилга /Дундговь, Сайнцагаан/
Тендер шалгаруулалтын дугаар: ЦЕГ/201901005

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Дундговь аймгийн Цагдаагийн газрын барилгын ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000,0 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн дундаж нь төсөвт өртөгийн 50 хувиас багагүй
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртөгийн 30 хувиас багагүй

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил
Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Төсөвт өртөгийн 40 хувиас багагүй

Барилга угсралтын тусгай зөвшөөрөл шаардлагатай

Тендерийн хамт 21,000,000 төгрөгийн дүнтэй цахим тендерийн баталгааг цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг 2019 оны 03-р сарын 22 ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим сиитемээр (www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 03-р сарын 22-ний өдрийн, 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхтэй.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээс авч болно.

Дундговь аймгийн
Орон нутгийн өмчийн газар 70593399, 88900015